



## “WHAT IS A CAUSE YOU WOULD LIKE TO FIGHT FOR OR ALREADY SUPPORT?”

### СЭДЭВТ АНГЛИ ХЭЛЭЭР УРАН ИЛТГЭХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

2017.10.23.

Улаанбаатар хот

МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Их Британи, Америк судлалын тэнхимээс “**What is a cause you would like to fight for or already support?**” сэдвийн хүрээнд англи хэлээр уран илтгэх тэмцээнийг зохион байгуулж буй бөгөөд төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургуулийн оюутан, залуус та бүхнийг идэвхитэй оролцохыг урьж байна.

**Зорилго:** Бакалаврын түвшний оюутнуудын англи хэлээр үзэл бодлоо цэгцтэй, ойлгомжтой, өөртөө итгэлтэй илэрхийлэх чадварыг хөхүүлэн дэмжиж үе тэнгийнхнийгээ нийгэмдээ эерэг өөрчлөлт авчрахад уриалан, хамтдаа хэлэлцэх боломжийг олгох.

**Хамрах хүрээ:** Их, дээд сургуулийн бакалаврын түвшинд суралцаж буй оюутнууд (нас, суралцаж буй мэргэжлийн чиглэл хамаарахгүй).

**Дэмжигч байгууллагууд:**

- “Talk Talk English” боловсролын төв
- “Nomads tours & expeditions” компани
- “Skytel” групп
- “Сэлэнгэ пресс” хэвлэлийн газар

**Тэмцээний тов:** 2017оны 12 сарын 8-ны өдрийн 14 цагт Монгол – Япон төвд.

**Үе шатууд:**

1-р шат: Дээрхи сэдвээр илтгэл бичиж ирүүлнэ.

2-р шат: Шилдэг 9 илтгэлийг шалгаруулна.

3-р шат: Шалгарсан 9 илтгэгч илтгэлээ сонсгож, илтгэлийн сэдвийн хүрээнд шүүгчдийн асуултад хариулна.

**Шүүгчдийн бүрэлдэхүүн:** Зохион байгуулагч, дэмжигч байгууллага болон бусад их, дээд сургуулийн англи хэлний багш нарын төлөөлөл оролцсон нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.

**Илтгэлийн шаардлага:** Илтгэлийг *A4* цаасан дээр *Times New Roman* үсгийн загвараар бичих бөгөөд үсгийн хэмжээ нь сэдэв *14*, илтгэгчийн нэр *12* (сэдвийн нэрний баруун доод мөрөнд харьяа сургуулийн нэр, холбоо барих утасны дугаар болон цахим хаягийн хамт бичнэ.), мөр хоорондын зай *1.5*см, үгийн тоо *400-500* байна.

**Илтгэлийг хүлээн авах хугацаа:** 2017 оны 11 сарын 24-ний 23:59 цаг хүртэл [speechcontest@num.edu.mn](mailto:speechcontest@num.edu.mn) цахим хаягаар хүлээн авна.

### **Шагнал, урамшуулал:**

#### **1-р байр:**

- Мөнгөн шагнал – 150.000 төг
- Өргөмжлөл
- “Talk Talk English” боловсролын төвд 100%-ийн хөнгөлттэй суралцах эрхийн бичиг
- “Nomads tours & expeditions” компанид хөтөч – орчуулагчаар ажиллахад авдаг Англи хэлний шалгалтыг дүйцүүлэх
- “Skytel” группын урамшуулал
- “Сэлэнгэ Пресс” –ийн урамшуулал

#### **2-р байр:**

- Мөнгөн шагнал – 100.000 төг
- Өргөмжлөл
- “Talk Talk English” боловсролын төвд 75%-ийн хөнгөлттэй суралцах эрхийн бичиг
- “Nomads tours & expeditions” компанид хөтөч – орчуулагчаар ажиллахад авдаг Англи хэлний шалгалтыг дүйцүүлэх
- “Skytel” группын урамшуулал
- “Сэлэнгэ Пресс” –ийн урамшуулал

#### **3-р байр:**

- Мөнгөн шагнал – 50.000 төг
- Өргөмжлөл
- “Talk Talk English” боловсролын төвд 50%-ийн хөнгөлттэй суралцах эрхийн бичиг
- “Nomads tours & expeditions” компанид хөтөч – орчуулагчаар ажиллахад авдаг Англи хэлний шалгалтыг дүйцүүлэх
- “Skytel” группын урамшуулал
- “Сэлэнгэ Пресс” –ийн урамшуулал

**Холбоо барих утас:** 91983138, 91719104, 99994065